



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/29

Даланзадгад

Хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.7.4 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 4.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бага насны хүүхэд, хөхүүл эхийн дархлаа дэмжих, өвчлөл болон бичил тэжээлийн дутлаас сэргийлэх зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан 6-59 сартай хүүхдэд, төрсөн эхэд уулгах өндөр тунт А аминдэмийн хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Өндөр тунт А аминдэмийг түгээхдээ 6-59 сартай хүүхдүүд болон төрсөн эхчүүдийг бүрэн хамруулж, зохистой хэрэглээнд хяналт тавьж, хугацаанд нь тайлагнаж ажиллахыг бүх эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу түгээх ажлыг зохион байгуулж, тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хугацаанд нь хүргүүлэхийг эмийн хангамж хариуцсан мэргэжилтэн /Д.Сэлэнгэ/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн Төвийн дарга /М.Булганчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын
2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн
А/29 тоот тушаалын хавсралт

**ӨНДӨР ТУНТ А АМИНДЭМИЙГ 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД,
ТӨРСӨН ЭХЭД ТҮГЭЭХ ХУВААРЬ**

№	Эрүүл мэндийн төвийн нэр	6-11 сартай нийт хүүхдийн тоо /2019-05-01-ний байдлаар/	А аминдэм 200 000 ОУН Хуваарилсан тоо 1/2 капсулаар уулгах/	12-59 сартай нийт хүүхдийн тоо /2019-05-01-ний байдлаар/	А аминдэм 200 000 ОУН Хуваарилсан тоо	Төрсөн эхэд уулгах	А аминдэм 200 000 ОУН Хуваарилсан тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Баяндалай ЭМТ	25	13	193	181	5	199	78.00	15,522.00
2	Баян-Овоо ЭМТ	22	11	113	101	5	117	78.00	9,126.00
3	Булган ЭМТ	29	15	123	111	5	131	78.00	10,218.00
4	Гурвантэс ЭМТ	44	22	410	398	30	450	78.00	35,100.00
5	Мандал-Овоо ЭМТ	31	16	168	156	5	177	78.00	13,806.00
6	Манлай ЭМТ	56	28	218	206	10	244	78.00	19,032.00
7	Ноён СДЭ	40	20	140	128	5	153	78.00	11,934.00
8	Номгон ЭМТ	37	19	216	204	10	233	78.00	18,174.00
9	Сэврэй ЭМТ	30	15	156	144	5	164	78.00	12,792.00
10	Ханбогд СДЭ	150	75	768	756	30	861	78.00	67,158.00
11	Ханхонгор ЭМТ	15	7	150	138	0	145	78.00	11,310.00
12	Хүрмэн ЭМТ	20	10	100	88	5	103	78.00	8,034.00
13	Цогт- Овоо ЭМТ	32	16	187	175	5	196	78.00	15,288.00
14	Цогтцэций СДЭ	0	0	0	0	40	40	78.00	3,120.00
15	Энэрхүй-Ухаан ӨЭМТ	175	88	794	717	0	805	78.00	62,790.00
16	Өнө-Орших ӨЭМТ	110	55	750	670	0	725	78.00	56,550.00
17	Шимбилэг ӨЭМТ	130	65	980	900	0	965	78.00	75,270.00
18	Энхийн хүслэн ӨЭМТ	119	60	897	817	0	877	78.00	68,406.00
19	БОЭТ	0	0	0	0	500	500	78.00	39,000.00
	Нийт дүн	1065	535	6363		660	7085	78.00	552,630.00
	Орлого	515		5154		1416	7085	78.00	552,630.00

Тайлбар: 6-11 сартай хүүхдэд 200 000* ОУН тунтай А аминдэмийг Эрүүл Мэндийн Сайдын 2013 оны 470 дугаар тушаалын дагуу 1/2 капсул (3 дусал)-ыг 100 000 ОУН-р тооцон уулгана.

Хуваарь гаргасан: Эмийн хангамж
хариуцсан мэргэжилтэн /Д.Сэлэнгэ/